



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/383

Булган сум

Бичил уурхайн гэрээ байгуулсан  
нөхөрлөлүүдийн эвдэрсэн газрын  
нөхөн сэргээлтийг хүлээн авах байнгын  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 296 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/439 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бичил уурхайн гэрээ байгуулсан нөхөрлөлүүдийн эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хүлээн авах байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Сумын Засаг дарга  
Гишүүд: Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын  
Улсын байцаагч  
Байгаль орчны газрын Газрын хэвлийн ашиглалт,  
хамгаалалт хариуцсан мэргэжилтэн  
Сумын газрын даамал  
Сумын Байгаль хамгаалагч  
Сумын иргэний төлөөлөл  
Нарийн бичгийн дарга: Сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

2. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын холбогдох стандартын дагуу хүлээн авч ажиллахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

